

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2020 оны жилийн эцэс)

**Байгууллага:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

**Тодруулга өгөх албан тушаалтан, холбоо барих утас:** Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг, утас: 99250593.

**Огноо:** 2021.01.15

Д/д		Хөтөлбөрийн танилцуулга хэсэг	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх	
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө	
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ” гэнэ).	
5.	Хэрэгжих нийт хугацаа	6 жил	
6.	Хөтөлбөрийн зорилтууд:	<p><b>Зорилт 2.</b> төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 3.</b> төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.</p>	
7.	Зардал	Төсөв	Тайлбар: ТӨБЗГ-ын 2020 оны төсөвт авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр тусгайлан төсөв батлагдаагүй болно.
		Үүнд:	
		2020 онд	Төсөв -
			Гүйцэтгэл -
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>			

8. Хөтөлбөрийн арга хэмжээ:	Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ бүрээр, хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг дор дурдсанаар тайлагнав.
<p>2 дугаар зорилтын хүрээнд:</p> <p>4.1.2.4.1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох</p>	<p>2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл (2 арга хэмжээ):</p> <p><b>ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ</b></p> <p>4.1.2.4.1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Төрийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нар ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал нэн чухлаар тавигдаж байгаа бөгөөд энэ асуудал Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдан батлагдсан болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хуулийн зохицуулалтыг тодорхой болгох талаар ажиллаж байна.</p> <p>2020 онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 15 этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийсэн бөгөөд 2019 онд хэрэгжүүлсэн 4 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайланг оролцуулан нийт 19 шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн илэрсэн зөрчил, дутагдлын дүнг баталгаажуулсан байна. 2020 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 19 хуулийн этгээдэд хийсэн баримтын шалгалтын дүнгээр нийт 21.29 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн байна /Хавсралт дахь 1 дүгээр хүснэгтээр харуулав/.</p> <p>2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан 19 хуулийн этгээдэд хийгдсэн төлөвлөгөөт баримтын хяналт шалгалтын дүнгээр 21,290.74 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд нийт зөрчлийн 4,804.64 сая төгрөг буюу 22.57%-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 10,464.75 сая төгрөг буюу 49.15%-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 4,093.01 сая төгрөг буюу 19.22%-ийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 1,928.34 сая төгрөг буюу 9.06%-ийг Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийг зөрчсөн зөрчил, дутагдал тус тус эзэлж байна /Мэдээллийг хавсралт дахь 1 болон 2 дугаар зургаар харуулав/.</p> <p>Төлөвлөгөөт бус баримтын шалгалтыг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд хийж, тайлан, дүгнэлтийг тухайн ажлын хэсгийн нарийн бичигт нэгтгүүлэх, газрын удирдлагын бүрэлдэхүүн, холбогдох байгууллагад танилцуулах арга хэмжээ авч ажиллав /Төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн</p>

<p>4.1.2.4.2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх</p>	<p>этгээдийн жагсаалтыг хавсралт дахь 2 дугаар хүснэгтээр харуулав/.</p> <p>Мөн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2020 онд төсөвт 7 байгууллагын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд системийн хяналт шалгалт хийснээс 6 нь төрийн өмчийн эмнэлэг, 1 их сургууль байна. Эдгээр 7 байгууллагад нийт дүнгээр 370.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн дүнтэй байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дийлэнхийг төсвийн хөрөнгөөр бий болж байгаа эд хөрөнгөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөлгүй авдаггүй, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажилладаггүй болох нь тогтоогдсон /Хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчийн эмнэлэг, сургуулийн жагсаалтыг 3 дугаар хүснэгтээр, зөрчлийн мэдээллийг 3 дугаар зургаар харуулав/.</p> <p><b><u>Өөрийн үнэлгээ: 70.0 хувь</u></b></p> <p><b>ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ</b></p> <p>4.1.2.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар олгосон чиг үүргийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү эдийн засгийн үйл ажиллагаа, төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт, эзэмшилт, ашиглалтын байдалд хийсэн хяналт шалгалт, түүний мөрөөр авах арга хэмжээний хүрээнд гаргасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, зөвлөмж, чиглэлд тухайн байгууллагад дотоод хяналтыг сайжруулах асуудлыг тусган төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хүргүүлж ажилласан.</p> <p>2020 онд хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит 43 (2019 онд хийсэн шалгалтад хамрагдсан 4 байгууллага орсон) хуулийн этгээдэд нийт дүнгээр 117 арга хэмжээг хяналт шалгалтын тайланд тусган, 140 арга хэмжээг хяналт шалгалтын мөрөөр гарсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэрт тусган үүрэг даалгавар өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна.</p> <p>Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлт, шалгалтын тайлангаар өгсөн үүрэг даалгавар, цаашид авах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2020 онд төрийн өмчит 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт тавин ажиллав. Шалгалтын үр дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа байдал, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн ногдол ашиг болон түрээсийн орлогыг төвлөрүүлсэн зэрэг эерэг үр дүн гарсан байна гэж дүгнэв.</p> <p><b><u>Өөрийн үнэлгээ: 70.0 хувь</u></b></p>
---	--

<p><b>3 дугаар зорилтын хүрээнд:</b></p> <p>4.1.3.1.2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p><b>3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл (1 арга хэмжээ):</b></p> <p><b>ТӨБЗГ – ТӨХШХ, ТӨБАХ</b></p> <p>4.1.3.1.2. 2020 онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнээс баримтын шалгалтыг 15, системийн шалгалтыг 7, гүйцэтгэлийн шалгалтыг 10 хуулийн этгээдэд тус тус хийсэн. Түүнчлэн, төлөвлөгөөт бус баримтын шалгалтыг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд гүйцэтгэсэн байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад төрийн хяналт шалгалт хийж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ажиллав. Хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дахин гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авахын зэрэгцээ зөрчил, дутагдал гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг судлах, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах чиглэлээр ажилласан байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэл болон зардлыг бууруулах талаар дүгнэлт гарган, шалгалтын тайланд тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлж, цаашид авах арга хэмжээ, тогтоол шийдвэрт тусган холбогдох байгууллагад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажиллав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь хот, орон нутаг хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний орлогоос 8 хувийг авч байна. Дээрх ажил үйлчилгээг гүйцэтгэхэд үйлдвэрийн газраас гарч байгаа зардал нь орлогоос давж байгаа тул автобус тээврийн компаниудтай байгуулсан гэрээг судлан үзэж дээрх үйлчилгээнээс авч байгаа орлогыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч эргэн танилцуулахыг даалгасан.</li> <li>2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ-ын борлуулалт, үйлчилгээний орлого, зарлагын байдалд дүн шинжилгээ хийж, орлогод тулгуурлан зардлыг төлөвлөх, үйл ажиллагааны чиглэлийг нэмэгдүүлэх талаар бодлогын яамтай хамтарч санал дүгнэлт боловсруулан танилцуулах зөвлөмж, үүрэг өгсөн.</li> <li>3. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааг өргөтгөх, орлого үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг чиг үүрэгтэй нь уялдуулан судалж, дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээний үр дүнг шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгасан.</li> <li>4. “Монгол-Ус” ТӨҮГ-ын хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт орж, цаашид байгууллагын үр ашигт нөлөөлөх эрсдэл үүссэнтэй холбогдуулан чиг үүргийн шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулан тус байгууллагад болон ТӨБЗГ-ын ТӨУЗХ-т салбарын яамтай хамтарч зохих арга хэмжээ авах</li> </ol>
--	---

талаар шалгалтын мөрөөр гарсан ТӨБЗГ-ын тогтоол шийдвэрт тусган хэрэгжилтийг хангуулан ажиллаж, биелэлтийг гаргуулсан.

Төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны биелэлтийг цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан цахим хэлбэрээр дүгнэв. 2020 онд төрийн өмчит 961 хуулийн этгээд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнүүлснээс 182 хуулийн этгээд “сайн”, 779 хуулийн этгээд “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнэхдээ холбогдох журмы дагуу 5 үндсэн үзүүлэлтээр байгууллага тус бүрийг дүгнэсэн бөгөөд улсын дундаж үнэлгээ “хангалттай” буюу 94.1 хувьтай, өнгөрсөн оны дүнгээс 2.1 хувиар өссөн дүнтэй байна /Гэрээний биелэлтийн дүнгийн товчоог хавсралт дахь 4 дүгээр хүснэгтээр танилцуулав/.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 597 дугаар тогтоол гаргасан бөгөөд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авах талаар зөвлөмж боловсруулан төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэхээр бэлтгэж байна. Түүнчлэн төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эзэмших, ашиглах газрыг баталгаажуулах, үнэлэх ажлыг бүрэн хийж дуусгах, тэг үлдэгдэлтэй буюу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэлгээ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох зэрэг ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчил, дутагдал гарч байгааг 2021 онд зохион байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын бэлтгэл хангах ажлын хүрээнд шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд цаашид авах арга хэмжээтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох чиглэлийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн байна.

**Өөрийн үнэлгээ: 90.0 хувь.**

9.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал: -			
		Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдсон дутагдалтай тал: Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоог хангаж ажиллах асуудал дутагдалтай байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд хамаарах Төрийн өмчийн асуудлаар орон нутаг дахь хуулийн этгээдэд хийгдэх хяналт шалгалтын ажил томилолтын зардалгүйгээс хийгдэх боломжгүй болсон. Үүнд, КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио, түүнтэй холбоотойгоор томилолтын зардлыг зогсоосон асуудал нөлөөлсөн.			
		Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдсон анхаарах асуудал: Улсын төсөвт тусгуулах зорилгоор тодорхой асуудлаар шаардлагатай төсвийн тооцоо хийж, санал оруулахад батлагдахгүй байгаа. Байгууллагын урсгал зардал хангалттай биш тул шаардлагатай зардлыг санхүүжүүлэх боломжгүй.			
10.	Санал	Цаашид хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын санал: 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох зохион байгуулалтын нэгж, албан хаагчдын хариуцан гүйцэтгэх ажлыг тусган хэрэгжүүлэхэд анхаарах (дотооддоо); 2. Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг Авлигатай тэмцэх газартай хамтран хэрэгжүүлэх.			
11.	Шаардагдах төсөв	Цаашид хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэх ажилд шаардагдах төсвийн тухай: Шаардлагатай төсөв батлуулах ажилд дэмжлэг үзүүлэх.			
12.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалтгүй.			
13.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 55 албан хаагчид, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдийн 150 албан хаагч.			
<b>Төрийн тухайн байгууллагад хамаарах</b>					
14.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	<b>Биелэлт (дундаж)</b>	<b>Зорилтын тоо (арга хэмжээ)</b>	<b>Зорилт 2 (2 арга хэмжээ)</b>	<b>Зорилт 3 (1 арга хэмжээ)</b>
		76.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”	2 (3)	70.0 хувь	90.0 хувь

15. Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (АТГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ
	..... %

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО / ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ГАНБОЛД

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ


Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хийсэн  
баримтын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн



№	Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн нэр	Тогтоолын		Илэрсэн зөрчил, дутагдлын дүн /төгрөгөөр/
		огноо	дугаар	
1	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ		Засгийн газрын хуралдаан	-
2	"Монголросцветмет" ТӨҮГ			-
3	"МИАТ" ТӨХК			-
4	"Монгол-Ус" ТӨҮГ	5/5/2020	238	57,783,276.91
5	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ	5/5/2020	239	368,870,000.00
6	"Техник спортын төв" ТӨҮГ	5/5/2020	237	1,283,239,100.00
7	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	7/6/2020	326	798,200,000.00
8	"Цагаан шонхор" ТӨҮГ	7/6/2020	327	47,508,100.00
9	"Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" ТӨҮГ	7/6/2020	325	417,699,826.00
10	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК	10/20/2020	500	132,587,500.00
11	"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК	10/20/2020	501	1,923,429,870.00
12	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	12/8/2020	601	161,400,000.00
13	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК	11/3/2020	535	623,939,360.00
14	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	11/3/2020	536	293,404,400.00
15	"Геологийн төв лаборатори" ТӨҮГ		Шалгалтын тайлан боловсруулж байгаа.	
16	"Монголын цахилгаан холбоо" ХХК	5/5/2020	235	3,573,800,000.00
17	"Харгуй" ТӨХК	7/6/2020	324	78,100,000.00
18	"Монголын төмөр зам" ТӨХК	5/5/2020	270	11,077,380,000.00
19	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	5/5/2020	236	453,410,000.00
<b>Нийт дүн</b>				<b>21,290,751,432.91</b>

1 дүгээр зураг


Баримтын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /сая. төгрөг/





2 дугаар зураг

Баримтын хяналт шалгалтаар илэрсэн хууль тогтоомжийн зөрчлийн дүн /сая.төгрөг/



2 дугаар хүснэгт

Төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх болсон тушаал шийдвэр
1	"Геологийн төв лаборатори" ТӨҮТ	ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/3522 албан бичиг, ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/01 дүгээр тушаал
2	"Төрийн орон сууцны корпорац" ТӨХК	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/23 дугаар тушаал
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/24 дүгээр тушаал
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	ТӨБЗГ-ын даргын 2020 оны өдрийн А/30 дугаар тушаал
5	"Эрдэнэс Таван Толгой" ХК	Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн удирдаж
6	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮТ	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/60 дугаар тушаал
7	"Төрийн орон сууцны корпорац" ТӨХК	ЗГХЭГ-ын даргын 2020 оны 63 дугаар тушаал


3 дугаар хүснэгт

Системийн хяналт шалгалтад хамрагдсан төсөвт байгууллага, зөрчлийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тогтоолын		Илэрсэн зөрчил, дугаардын дүн /төгрөгөөр/
		олноо	дугаар	
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	2020-12-08	605	47,900,000.00
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	2020-12-28	713	27,400,000.00
3	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	2020-12-08	604	213,500,000.00
4	Арьсны өвчин судлалын үндэсний төв	2020-12-08	606	1,400,000.00
5	Эрүүл мэндийн үндэсний төв	2020-12-08	603	53,900,000.00
6	Гэмтэл согот судлалын үндэсний төв	2020-12-08	602	10,200,000.00
7	Дотоод хэргийн их сургууль	2020-12-28	714	16,100,000.00
<b>Нийт дүн</b>				<b>370,400,000.00</b>

3 дугаар зураг

Төсөвт байгууллагад хийсэн системийн шалгалтаар илэрсэн зөрчил



4 дүгээр хүснэгт

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны биелэлтийн дүнгийн товчоо

Гэрээ дүгнүүлсэн хуулийн этгээдийн тоо	Шалгуур үзүүлэлт, авсан онооны дүндэж дүн (хувь)					
	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалал-тын байдал (30/25)	Хөрөнгийн хөдлөл өөрчлөгт, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал (40/40)	Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал (10/10)	Газар эзэмших, ашиглах эрхийн байдал (10/10)	Гэрээ дүгнүүлэх бэлтгэл хангасан байдал (10/10)	Нийт оноо (хувь)
961	23.54	37.72	7.98	7.9	9.11	94.1